

## 2018 ОНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ХАГАС ШИГШЭЭ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

### Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Тэмцээний зорилго нь 2018 оны Ази тивийн АШТ болон Улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулахад оршино.
- 1.2. Тэмцээн эрэгтэй, эмэгтэй гэсэн ангиллаар **нээлттэй** явагдана.
- 1.3. Тэмцээн Монголын даамын холбооны тэмцээний дүрмийн дагуу явагдана.
- 1.4. Тэмцээний дүнг тамирчдын дотоод, гадаад чансаа бодоход тооцно.

### Хоёр. Тэмцээний журам

- 2.1. Тэмцээн **2018 оны 1 дүгээр сарын 12-ноос 14-ны өдрүүдэд** МУБИС-ийн төв байранд явагдана.
- 2.2. Тэмцээнийг Монголын даамын холбоо зохион байгуулж, шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилно.
- 2.3. Бүртгэлийг Монголын даамын холбооны байранд **оролцох эрхийн тоог гүйцтэл эсвэл 2018 оны 1 дүгээр сарын 11-нийг дуустал** хүлээн авна.
- 2.4. Тэмцээнд оролцох эрхийн хураамж 20,000 төгрөгийг тушааж, бүртгэлийг баталгаажуулна.
- 2.5. Тэмцээнд оролцох эрх (мандат)-ийг бүртгэлээ баталгаажуулсан эхний *эрэгтэй 80, эмэгтэй 50* тоглогчид олгоно.
- 2.6. 2018 оны бүх тэмцээнд **Монголын даамын холбооны тоглогчийн лиценз** бүхий тамирчин оролцох эрхтэй. (*Лицензийн жилийн хураамж насанд хүрэгчид 20,000 төг, хүүхэд 10,000 төг байна*)
- 2.7. Цагийн хяналт талдаа хамгийн багадаа **1 цаг** байна.
- 2.8. Швейцарь системээр 9 өрөг тоглож дүнг гаргана.
- 2.9. Тоглогчдыг хожлын тоогоор цуваагаар байр эзлүүлэн, хожлын тоо тэнцсэн үед дараахь шалгуурыг баримтална. Хэрэв рейтинг харгалзахгүй бол:
  1. Швейцарь системийн Солкофын коэффициент
  2. Швейцарь системийн Солкофын коэффициент (хоёр талаас нь -1,-2...)

### Гурав. Шагнал, урамшуулал

- 3.1. Тэмцээнд эхний 3 байр эзэлсэн эрэгтэй, эмэгтэй тус бүр 3 тамирчинд Азийн АШТ-д оролцох эрх олгоно.
- 3.2. Эрэгтэй, эмэгтэй ангилал тус бүрт эхний **8 байрт** шалгарсан тамирчдад шигшээ тэмцээнд оролцох эрх олгоно.

3.3. Тамирчин авбал зохих онооноос дараах болзлыг хангасан тохиолдолд спортын цол, зэргийг биелүүлнэ.Үүнд:

- 75% - Спортын мастер цол
- 70% - Спортын мастерын 2 балл
- 60% - Спортын мастерын 1 балл
- 55% - Спортын дэд мастер
- 50% - Спортын дэд мастерын 2 балл
- 45% - Спортын дэд мастерын 1 балл
- 40% - Спортын 1-р зэрэг
- 35% - Спортын 2-р зэрэг
- 30% - Спортын 3-р зэрэг

3.4. **2017** оны Улсын аварга шалгаруулах тэмцээний медальт байрын тамирчид өөрийн хүсэлтээр хагас шигшээ тэмцээнд оролцож болох бөгөөд энэ тохиолдолд шалгарах тамирчдын тоог тэдгээр тамирчдын тоогоор нэмэгдүүлнэ. Харин хагас шигшээ тэмцээнд оролцсон медальт тамирчин Азийн АШТ болон УАШТ-ий шигшээд шууд орох эрхээ эдлэхгүй болно.

#### МОНГОЛЫН ДААМЫН ХОЛБОО

Харилцах утас: 99164205

Email: [daam@mondaam.mn](mailto:daam@mondaam.mn)

Web: [www.mondaam.mn](http://www.mondaam.mn)